



МОНГОЛ УЛС
ДУНГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/305

Миндалговь

Г

1

Өмчлөлийн газраа өвлөн авах тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 5.1.4, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Өмчлөлийн газраа өвлөн авах тухай хүсэлт гаргасан иргэдийн хүсэлт, ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа 2 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын засаг дарга /Р.Мөнхтогтох/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Газрын талбайн хэмжээ болон хаягийн өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс /Ж.Өлзийжаргал/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 664 дүгээр захирамжийн хавсралтын 30, 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 883 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200833